

Монголын Эмнести Интернэшнл" байгууллагын

XIX Чуулганаар шинэчлэн найруулж батлав.

2017.06.17. Улаанбаатар хот. Монгол улс

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

1. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн алсын хараа нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон олон улсын хүний эрхийн бусад баримт бичигт тусгагдсан хүний эрхийг дэлхийн хүн бүрт эдлүүлэхэд оршино. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн эрхэм зорилго нь хүний бүхий л эрхийг хамгаалахын төлөө өөрийн үйл ажиллагааны хүрээнд хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа хийх ба үйл ажиллагаа явуулж, бодитой арга хэмжээ авах явдал мөн.

ҮНЭТ ЗҮЙЛС

2. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ нь олон улсын эв санааны нэгдэл, хохирогч бүрийн төлөө идэвхитэй хүчин чармайлт гаргаж, хүний жам ёсны эрхийн түгээмэл, халдашгүй дархан, бие даасан хараат бус байдал, ардчилсан, харилцан ойлголцох зарчмыг эрхэмлэсэн дэлхий даяархи хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн мөн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ нь үйл ажиллагаагаа засгийн газар, засгийн газар хоорондын байгууллага, улс төрийн зэвсэглэсэн бүлэглэл, компани болон төрийн бус оролцогч руу чиглүүлнэ.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ нь хүний эрхийн зөрчлийг илрүүлэхийн төлөө нарийн нягт нямбай, түргэн шуурхай, уйгагүй, хүчин чармайлт гаргана. Хүний эрхийн нөхцөл байдлуудыг үндэслэн системтэй, шударга судалгаа хийнэ. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ аль ч Засгийн газарт хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэх, батлах, хууль дүрмээ хянаж үзэхийг шаардах, хүний эрхийн боловсрол, соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулна.

4. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ нь сайн дурын гишүүнчлэл дээр үндэслэгдсэн дэлхий нийтийн хэмжээний байгууллага бөгөөд тус байгууллагын Монгол улс дахь салбар нь Монголын Эмнести Интернэшнл (цаашид МЭИ) мөн.
5. МЭИ нь Олон Улсын Зөвлөлийн Хуралдаанаар баталсан ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн дүрэм, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээ, Монгол улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагуудын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.
6. МЭИ нь чуулганаар батлагдсан МЭИ-ийн дүрэм, МЭИ-ийн ёс зүйн дүрмийг мөрдөнө.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

А. Чуулган

7. МЭИ-ийн удирдах байгууллага нь 2 жилд 1 удаа хуралдах Чуулган мөн. Чуулган нь дараахь бүрэн эрхтэй
 - i) Монголын Эмнести Интернэшнлийн нэрийн өмнөөс түүний бодлого стратегийг тодорхойлж хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулах
 - ii) Монголын Эмнести Интернэшнлийн эрхэм зорилт, зорилго, үнэт зүйлсийг тодорхойлж, хэрэгжүүлэх
 - iii) Нэгдсэн стратеги төлөвлөгөө болон санхүүгийн стратегийг тодорхойлох, мөрдөх
 - iv) МЭИ-ийн дүрмийг хэлэлцэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах
 - v) МЭИ-ийн Удирдах болон Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж, Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг сонсоно
 - vi) МЭИ-ийн Удирдах болон Хяналтын зөвлөлийг сонгох
 - vii) МЭИ-ийн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг дүрмийн дагуу явагдаж буй эсэхийг баталгаажуулах
 - viii) Дүрэмд нийцсэн бусад эрх
8. МЭИ-ийн Удирдах зөвлөлийн бүрэн эрхэд үл хамаарах үйл ажиллагаатай холбогдсон онц тулгамдсан асуудлаар МЭИ-ийн Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.
9. Бүлэг нь Чуулганаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн асуудлаар бусад бүлэгт санал гаргаж болно. Уг саналыг 3-аас дээш бүлэг дэмжвэл хамтран тогтоолын төсөл боловсруулан Чуулганаар хэлэлцүүлэхээр Удирдах Зөвлөлд өргөн барина. Тогтоолын төслийг чуулган болохоос 3 сарын өмнө өргөн барих бөгөөд Удирдах Зөвлөл нь уг тогтоолын төслийг гишүүд, бусад бүлгүүдээр хэлэлцүүлэх үүрэг хүлээнэ.
10. Чуулганд бүлгүүд оролцсон гишүүдийнхээ тооноос үл хамааран саналын 5 эрхтэй байна. Чуулганд бүлгийн төлөөллийг дараах тоогоор сонгон оролцуулна.
 - i) 50 хүртэлх гишүүнтэй бол 5 төлөөлөгч
 - ii) 50-99 гишүүнтэй бол 6 төлөөлөгч
 - iii) 100-199 гишүүнтэй бол 7 төлөөлөгч
 - iv) 200-499 гишүүнтэй бол 8 төлөөлөгч
 - v) 500 ба түүнээс олон гишүүнтэй бол 9 төлөөлөгч сонгож оролцуулна.
11. Чуулганы төлөөлөгчдөөс 5 хүний бүрэлдэхүүнтэй Сонгуулийн хороог байгуулан Удирдах зөвлөл, түүний дарга, дэд дарга болон Хяналтын зөвлөл, түүний даргын сонгуулийг зохион байгуулж дүнг гарган Чуулганд танилцуулна.
 - 11.1 Сонгуулийн хороонд ЭИ-ийн аливаа сонгуульд нэрээ дэвшүүлээгүй, сонгуульд үүрэг хүлээгээгүй, төлөөлөгч сонгогдоно. Хороонд бүлгээс нэгээс илүүгүй төлөөлөгч нэр дэвшинэ.
 - 11.2 Сонгуулийн хороо нь Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийг бүртгэн, дүрэмд заасан шалгуурын дагуу нягталж нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргаж Чуулганд танилцуулна.
 - 11.3 Сонгуулийн хороо нь саналын хуудсыг бэлтгэж санал хураах ажлыг зохион байгуулна.
 - 11.4 Сонгуулийн хорооны ажил нь ардчилал ба ЭИ-ийн үнэт зүйлсэд

харшлахгүйгээр шударга ил тод явагдана.

11.5 Сонгуулийн дүн Чуулганаар батламжлагдсанаар Сонгуулийн хорооны үйл ажиллагаа дуусгавар болно.

- 12 Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд нэр дэвшүүлэх хугацаа нь Чуулган болохоос 7 хоногийн өмнө дуусна. Нэр дэвшүүлэх хугацаа дууссанаас хойш Чуулган эхлэх хүртэл нэр дэвшигчдийг ялгаварлалгүйгээр гишүүдэд танилцуулна.

Б.Удирдах зөвлөл

- 13 Чуулганы хооронд тус байгууллагын үйл ажиллагааг Чуулганаас сонгогдсон МЭИ-ийн Удирдах зөвлөл эрхлэн явуулна.

- 14 МЭИ-ийн Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

14.1 Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх

14.2 МЭИ-ийн үйл ажиллагааг удирдан зохицуулах

14.3 Эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлс, үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх шийдвэр гаргах

14.4 Олон улсын ба бүсийн төвтэй хамтран ажиллах

14.5 Нэгдсэн төсвийг батлах

14.6 Кампанит ажлыг зохион байгуулах шийдвэр гаргах

14.7 Бүлгүүдийг албан ёсоор бүртгэж, үйл ажиллагааг нь дэмжих, уялдуулах буюу зогсоох

14.8 Гүйцэтгэх товчооны гүйцэтгэх захирал, ажилтнуудыг ажилтан шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулан томилж, үйл ажиллагааг нь зохицуулах, хяналт тавих

14.9 Сонгон шалгаруулалтын дүнд Удирдах зөвлөлөөс томилогдсон Гүйцэтгэх захиралтай Удирдах зөвлөлийн дарга ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.

14.10 Тухайн жилийн гишүүний татварын хэмжээг тогтоох бөгөөд татвар ялгамжтай байж болно.

14.11 Дүрэмд нийцсэн бусад бүрэн эрх

14.12 удирдах зөвлөлийн гишүүн нь бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш 2 жилийн дотор Гүйцэтгэх товчоонд ажилтнаар орохыг хориглоно.

15. МЭИ-ийн Удирдах зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нууц санал хураалтаар сонгох бөгөөд дарга, дэд дарга, санхүүчийг удирдах зөвлөлийн гишүүдээс нэр дэвшүүлж нууц санал хураалтаар сонгон Чуулган батламжилна.

15.1 МЭИ-ийн үйл ажиллагааг Удирдах зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга удирдана.

15.2 Удирдах зөвлөлийн гишүүн нь үүргээ хангалтгүй биелүүлбэл, тодорхой шалтгааны улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Чуулганаар Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс сонгогдоогүй үлдсэн хүмүүсээс хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг Удирдах зөвлөлийн хурлаас нөхөн батламжилна.

- 16 Удирдах зөвлөлийн гишүүн нь дараахь шалгуурыг хангасан байна.

16.1 Манлайллын ба төлөөлөх чадвар ур чадвар өндөр, бодлого стратеги боловсруулах туршлагатай,

16.2 Багийн зохион байгуулалт, зөрчилдөөний менежмент ба харилцаа сайн

16.3 Хүний эрхийн талаархи мэдлэг өндөр, ЭИ-ийн үнэт зүйлийг хүлээн

зөвшөөрсөн, ёс зүйтэй

16.4 Хариуцлага хүлээх чадвартай

- 17 Удирдах зөвлөлийн сонгууль 2 жил тутамд нэг удаа болно.
- 18 Нэг удаагийн Удирдах зөвлөлийн сонгуулиар өмнөх удирдах зөвлөлийн гишүүдээс 5-аас илүүгүй хүний орон тоон дээр нэр дэвшүүлэлт хийнэ.
- 19 Өмнөх удирдах зөвлөлийн гишүүний идэвхи, оролцоо, санаачилгыг Удирдах зөвлөлийн Хөгжлийн хороо жагсаан гаргасны дараагаар хамгийн бага оноо авсан болон энэ дүрмийн 20-т заасан үндэслэл бүхий УЗ-ийн гишүүний орон тоон дээр нэр дэвшүүлэлт хийнэ.
- 20 Удирдах зөвлөлийн гишүүн нь дараалан 3 удаагаас дээш дахин сонгогдохгүй.
- 21 МЭИ-ийн Удирдах зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь Удирдах зөвлөлийн гишүүдийн хурал бөгөөд хоёр сар тутам хуралдаж асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Удирдах зөвлөлийн гишүүд нь шийдвэр гаргахад адил тэгш эрхтэй оролцоно. Удирдах Зөвлөлийн шийдвэр нь ТОГТООЛ хэлбэрээр гарна.
- 22 МЭИ-ийн Удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудлаар ажлын хэсгийг олон улсын төвтэй зөвшилцсөнөөр харьяалалдаа байгуулан ажиллуулж болно.
- 23 МЭИ-ийн Удирдах зөвлөл нь ажлаа олон улсын төвд болон Чуулганд, Чуулгангүй жилд тухайн жилийн 4-р улирлын бүх гишүүдийн уулзалтанд тайлагнана.
- 24 Удирдах зөвлөлийн гишүүн нь улс төрийн намын удирдах бүрэлдэхүүнд эсхүл УИХ-ын болон аймаг, нийслэлийн сонгуульд нэр дэвшсэн, сонгогдсон бол УЗ-д танилцуулан, удирдах зөвлөлийн гишүүнээс түдгэлзэнэ.
- 25 Удирдах зөвлөлийн гишүүн нь МЭИ-ээс хэрэгжүүлж буй аливаа төслийг шууд биечлэн хариуцах, эсхүл Гүйцэтгэх товчоотой гэрээ байгуулж нэгээс доошгүй төсөл дээр урт хугацаагаар хавсран ажиллахыг цээрлэнэ.
- 26 Удирдах зөвлөлд 14-25 насны нэгээс доошгүй залуу төлөөлөгч гишүүнийг сонгоно.

В/ Гүйцэтгэх товчоо

- 27 МЭИ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын байгууллага нь Удирдах зөвлөлөөс томилсон Гүйцэтгэх товчоо мөн.
 - 27.1 Гүйцэтгэх товчоо нь гүйцэтгэх захирал, чиглэл хариуцсан зохицуулагчидтай байна. Гүйцэтгэх товчооны үйл ажиллагааг гүйцэтгэх захирал шууд хариуцна. Гүйцэтгэх товчоонд ажиллах ажилтнуудтай гүйцэтгэх захирал хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулна.
 - 27.2 Гүйцэтгэх товчоо нь МЭИ-ийн Удирдах зөвлөлийн болон Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах бөгөөд ажлаа МЭИ-ийн Удирдах зөвлөл ба олон улсын төвд тайлагнана.
 - 27.3 Гүйцэтгэх товчооны ажил үүргийн хуваарийг Удирдах зөвлөлийн хурлаас батална.
 - 27.4 Гүйцэтгэх товчооны зардлын санг бүтцээс шалтгаалан МЭИ-ийн Удирдах зөвлөлийн хурлаас тогтоон нэгдсэн төсөвт багтаан батална.
 - 27.5 Гүйцэтгэх товчооны ажилтан нь үүрэгт ажпаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн дотор УЗ болон МЭИ-ийн бусад сонгуульд албан тушаалд нэр дэвшихийг хориглоно.

Г/ Хяналтын зөвлөл

28 Хяналтын зөвлөл нь МЭИ-ийн Чуулганы шийдвэрийн хэрэгжилт, МЭИ-ийн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх товчооны үйл ажиллагааны санхүүгийн зарцуулалтанд байнгын хяналт тавьж, Чуулганд, Чуулгангүй жилд тухайн жилийн 4-р улирлын бүх гишүүдийн уулзалтанд тайлагнана.

28.1 МЭИ-ийн Хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байх ба хяналтын зөвлөлийн гишүүдийг МЭИ-ийн Чуулганаас нууц санал хураалтаар олонхийн саналаар сонгоно.

28.2 Хяналтын зөвлөлийн сонгууль 2 жил тутамд нэг удаа болно.

28.3 Хяналтын зөвлөлд МЭИ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх товчооны ажилтан сонгогдохыг хориглоно. Зөвлөлийн ахлагчийг Хяналтын зөвлөлийн гишүүд сонгож Чуулганаар батламжилна.

28.4 Хяналтын зөвлөлөөс гаргах албан ёсны аливаа шийдвэр, акт, зөвлөмж, мэдэгдэлд Хяналтын зөвлөлийн гишүүдийн олонхи гарын үсэг зурснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

28.5 Хяналтын зөвлөл нь МЭИ-ийн санхүүгийн зарцуулалтыг хянах, шалгах, тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн магадлан шинжлэх, хөндлөнгийн хяналтын байгууллагын туслалцааг авч болно.

ГИШҮҮНЧЛЭЛ А. Гишүүн

29 МЭИ-ийн Гишүүн гэдэг нь ЭИ-ийн үзэл санаа, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө оролцоогоороо хувь нэмрээ оруулах, МЭИ-ийн дүрэмтэй танилцаж хүлээн зөвшөөрсөн, жилийн татвараа төлсөн хувь хүнийг хэлнэ. Гишүүн нь Чуулганд саналын эрхтэй оролцоно.

29.1 Дараахь үндэслэлээр гишүүнчлэл зогсоогдоно:

- i) Сайн дураараа гарах
- ii) ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн дүрмийн заалтыг ноцтой зөрчсөн үйл ажиллагаа явуулсан
- iii) Гишүүний татвараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэг жилээс дээш хугацаагаар төлөөгүй энэ талаар бүлгээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй
- iv) ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн орлого, эд хөрөнгийг зүй бусаар зарцуулсан, үрэгдүүлсэн, ашигласан
- v) ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн эрхэм зорилт ба зорилго, үнэт зүйлст илт харш үйлдэл хийсэн

29.2 Энэхүү заалтын (ii)-(v)-тай холбогдсон асуудлыг МЭИ-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж олон улсын төвд мэдэгдэнэ.

Б. Бүлэг

30 МЭИ-ийн үндсэн нэгж нь бүлэг мөн. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ-ийн олон улсын ба үндэсний дүрэм, хөтөлбөр, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, мэргэжил, ашиг сонирхол, нас хүйс, нутаг дэвсгэрийн зарчмаар нэгдсэн 10-аас доошгүй гишүүнтэй хэсгийг бүлэг гэнэ.

30.1 Бүлгийг МЭИ-ийн Удирдах зөвлөлөөс албан ёсоор баталгаажуулна. Бүлэг Удирдах зөвлөлөөс баталгаажсан шинэ бүлэг нь баталгаажсанаас хойш 3-аас доошгүй сар болсны дараагаар Чуулганд бүрэн эрхт төлөөлөгчөө оролцуулах, санал өгөх эрхтэй.

Бүлэг ахлагчтай байна. Ахлагчийг бүлгийн гишүүдийн саналаар сонгоно.

30.2 Бүлэг шаардлагатай гэж үзсэн асуудлаар МЭИ-ийн Удирдах зөвлөлтэй зөвшилцөж зохих дэмжлэг авна.

30.3 Бүлэг нь дотроо гишүүдийн сонирхол байршил үйл ажиллагааны онцлогоос хамааран баг, клуб, хэсэгтэй байж болно.

30.4 Бүлэг нь дүрэмд заасан шалгуурт нийцэхээргүй болсон, бүлгийн гишүүнчлэл дүрэмд заасан хэмжээнд хүрэхгүй байх, МЭИ-ийн санхүү, хөрөнгийг зүй бусаар ашигласан эсхүл бүлгийн гишүүдийн дийлэнхи олонхи нь бүлгээ татан буулгах санал гаргасан, МЭИ-ийн дүрмийг зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн бүлгийг татан буулгана.

31 Бүлэг дараахь эрх эдэлнэ:

31.1 "Эмнести Интернэшнл"-ийн олон улсын ба бүсийн төвөөс нэгдсэн хуваариар зохион байгуулж буй хүний эрхийн кампанит ажлуудад оролцох

31.2 "Эмнести Интернэшнл"-ийн олон улсын төв буюу МЭИ-ийн ажлын талаар санал дэвшүүлэх, мэдээлэл авах, сонгох, сонгогдох, хурал, чуулганд оролцох.

31.3 МЭИ-ийн Удирдах зөвлөлтэй зөвшилцсөнөөр сургалт сурталчилгаа бие даан явуулж, санхүүгийн туслалцаа авах

31.4 Шинэ гишүүн элсүүлэх

31.5 Бүлгийн гишүүдийн татвар, хандив, сан арвижуулах үйл ажиллагаанаас олсон орлогын 50 хүртэл хувийг дүрмээр хориглоогүй үйл ажиллагаанд Гүйцэтгэх товчооноос гаргаж зөвшөөрсөн журмаар зарцуулна.

31.6 Хурал, сургалтанд оролцох төлөөлөгчдийг бүлэг санал болгоно.

31.7 Дүрэмд заасан бусад үйл ажиллагаа

32 Бүлэг дараахь үүрэг хүлээнэ

32.1 "Эмнести Интернэшнл"-ийн олон улсын ба бүсийн төвөөс нэгдсэн хуваарьт кампанит ажлуудыг үндэсний хэмжээнд бие даан болон бусад бүлгүүдтэй хамтран явуулах

32.2 "Эмнести Интернэшнл"-ийн үндэсний ба олон улсын санхүүг арвижуулахад хувь нэмэр оруулах

32.3 "Эмнести Интернэшнл"-ийн хөдөлгөөнийг өргөжүүлэх, түүний эв нэгдлийг хамгаалах

32.4 Кампанит ажлын болон бусад тайланг тогтоосон хугацаанд МЭИ-д ирүүлэх

32.5 Нэгдсэн хуваарьт ороогүй дүрэм, хөтөлбөрөөс гадуурх ажилд "Эмнести Интернэшнл"-ийн нэрээр үл оролцох

32.6 Өөрийн оронд байгаа үзэл санааны хоригдлыг тухайн орны бүлгийн гишүүд ивээлдээ авч болохгүй.

В. Дэмжигч

33 МЭИ-ийн үйл ажиллагааг дэмжин жил бүр 5000 төгрөгөөс дээш төгрөгийн хандив өргөн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авч, өөрийн сонирголоороо үйл

ажиллагаанд оролцох хувь хүнийг дэмжигч гэнэ. Дэмжигч нь Чуулганд саналын эрхгүй оролцож болно.

34. Эмнести Интернэшнл нь өөрийн үйл ажиллагааг дэмждэг байгууллага, аж ахуйн нэгжтэй байж болно.

Г. Хүндэт гишүүн

35. МЭИ-ийн хүндэт гишүүнтэй байж болно. Хүндэт дарга, гишүүн нь МЭИ-ийг үүсгэн байгуулах, өргөжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулсан ОУНБДНГ-ын болоод МЭИ-ийн нэр хүнд бүхий хүн байна.

САНХҮҮЖИЛТ

36. МЭИ-ийн Удирдах зөвлөл нь тус байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ. МЭИ-ийн санхүү нь гишүүдийн татвар, дэмжигчдийн хандив, тусламж, дүрмийн дагуух үйл ажиллагааны орлого, олон улсын төвөөс ирүүлсэн дэмжлэг, зээлийн, өвийн болон төслийн хөрөнгөөс бүрдэнэ. Санхүүгийн журмыг МЭИ-ийн Удирдах зөвлөлийн хурлаар батална. Санхүүгийн журам нь Удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, бүх ажилтнуудад албан ёсоор танилцуулагдсан байна.
37. Банкны чекэнд нэгдүгээр гарын үсгийг санхүүч, хоёрдугаар гарын үсгийг гүйцэтгэх захирал зурах эрхийг Удирдах зөвлөлөөс шийдвэр гарган баталгаажуулна. Нэгдсэн төсвийн дагуу, санхүүгийн хүрээнд хөрөнгийг Захирал зарцуулан, Удирдах зөвлөл ба олон улсын төвд тус тус тайлагнана. Чуулган дээр санхүүч тайлагнана.
38. "Эмнести Интернэшнл"-ийн орлого, өмчийг зориулалтын бусаар зарцуулах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

БУСАД АСУУДАЛ

39. МЭИ өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, харилцах данс(төгрөгийн болон гадаад валютын) бэлэг тэмдэг, лого хэвлэлтэй байна.
40. МЭИ-ийн дүрмийг Чуулганы төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар батлах буюу нэмэлт өөрчлөлт оруулна.
41. МЭИ-ийг татан буулгах асуудлыг МЭИ-ийн Удирдах Зөвлөл Олон Улсын Нарийн Бичгийн Дарга Нарын Газартай зөвшилцөх бөгөөд Чуулганы төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй хувийн санал эсхүл Олон Улсын Гүйцэтгэх Хорооны шийдвэрээр татан буугдана. МЭИ татан буугдсан тохиолдолд өмч хөрөнгийг үндэсний холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол ОУНБДНГ шийдвэрлэнэ.
42. Бүлэг нь үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангаа санхүүгийн жилийн төгсгөлд Гүйцэтгэх товчоонд гарган өгнө.

/ТӨГСӨВ/